



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 13

Арвайхээр


Цалин шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 2014 оны 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 3.1 дэх заалт, аймгийн Засаг даргын “Зэрэг дэв олгох тухай” 2017 оны а/60 дугаар захирамжийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 2 дугаар сарын хурлын шийдвэрээр төрийн захиргааны албан тушаалын “Ахлах түшмэлийн дөтгөөр” зэрэг дэв дэвшүүлэн авсан тус сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Ц.Тунгалагийн үндсэн цалинг ТЗ-7-ын 4 дэх шатлал буюу 698795 /Зургаан зуун ерэн найман мянга долоон зуун ерэн тав/ төгрөг, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 15 хувь 104819 /Нэг зуун дөрвөн мянга найман зуун арван ес/, зэрэг дэвийн нэмэгдэл 20 хувь 139759 /Нэг зуун гучин есөн мянга долоон зуун тавин ес/, албан тушаалын нэмэгдэл урамшуулал 32 хувь 223614 /Хоёр зуун хорин гурван мянга зургаан зуун арван дөрөв/ нийт 1166987 /Нэг сая нэг зуун жаран зургаан мянга есөн зуун наян долоо/ төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

2. Ц.Тунгалагийн шинэчлэн тогтоосон цалинг 2017 оны 03 дугаар сарын 01-нээс тооцож олгохыг Нягтлан бодогч /М.Отгон/-д зөвшөөрсүгэй.

3. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн “Цалин шинэчлэн тогтоох тухай” 2014 оны 10 дугаар 29-ний өдрийн 38 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.АМАРТҮВШИН

